



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛИАГ  
**ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 05 сарын 01 өдөр

Дугаар MSD

Дархан

Эрүүл мэндийн салбарын 2023-2026 оны  
стратеги төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/609 дугаар тушаалыг үндэслэн ТУШААХ нь:

1.“Эрүүл мэндийн салбарын 2023-2026 оны стратеги төлөвлөгөө”-г хавсралтаар баталсугай.

2.Стратеги төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг Эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны төлөвлөгөө, стратеги төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн байгууллагын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.“Эрүүл мэндийн салбарын 2023-2026 оны стратеги төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангахад мэргэжил, арга зүйгээр хангаж, жил бүр хяналт үнэлгээ хийж үр дүнг тооцож ажиллахыг Эрүүл мэндийн газрын Хяналт шинжилгээ үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга (Б.Золбаясах), Хяналт үнэлгээний мэргэжилтэн (Ч.Мөнхцэцэг) нарт тус тус үүрэг болгосугай.


4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга (Д.Наранцэцэг), Удирдлага төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга (Б.Эрдэнэчимэг) нарт даалгасугай.

ДАРГА



Б.БАТЦЭНГЭЛ

Эрүүл мэндийн газрын даргын  
2023 оны 05 сарын 01 өдрийн  
01/ХР тоот тушаалын 2-р хавсралт



**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ГАЗРЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ**

**2023-2026 он**

**Эрүүл мэндийн салбарын 2023-2026 оны стратеги төлөвлөгөөний бүтэц, агуулга**

- Бүлэг 1. Нийтлэг үндэслэл.....
- Бүлэг 2. Мандатын шинжилгээ .....
- Бүлэг 3. Алсын хараа.....
- Бүлэг 4. Эрхэм зорилго.....
- Бүлэг 5. Орчны шинжилгээ.....
- Бүлэг 6. Стратегийн зорилго .....
- Бүлэг 7. Стратегийн зорилго ба салбар, нутаг дэвсгэрийн нэгж байгууллагын бүтцийн уялдаа зураглал.....
- Бүлэг 8. Стратегийн зорилгыг хэмжих шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин.....
- Бүлэг 9. Хавсралт (хөгжлийн стратеги төлөвлөгөө 2023-2026).....

## **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

### **1.1.Товч танилцуулга**

Эрүүл мэндийн газар нь үйл ажиллагаандаа Эрүүл мэндийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон нутгийн өөрөө удирдах байгууллага, аймгийн Засаг даргын шийдвэр, холбогдох бусад хууль тогтоомж, стандартыг харъяа эрүүл мэндийн байгууллагуудад хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, бодлого арга зүйгээр хангах, тэдгээрийн үйл ажиллагаанд хяналт, үнэлгээ хийх үйл ажиллагааг уялдуулан зохицуулах эрх, үүргийг гүйцэтгэх төрийн байгууллага юм. Мөн иргэдэд тэгш, хүртээмжтэй, чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эмч, эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжил, ур чадвараа дээшлүүлэх боломжоор хангах, үйл ажиллагаа нь иргэдэд нээлттэй, ил тод, иргэдийн оролцоог хангасан байх зарчмыг баримталдаг. Эрүүл мэндийн газрын удирдлагад аймгийн нэгдсэн эмнэлэг 1, Өрхийн эрүүл мэндийн төв 5, Сумын эрүүл мэндийн төв 3, хувийн хэвшлийн ортой эмнэлэг 12, клиник эмнэлэг 53, сувилал 6, лаборатори 6, халдваргүйтгэл, шавьж мэрэгч устгал 3, эм хангамжийн байгууллага 7, эмийн сан 67 ажиллаж байна.

Эрүүл мэндийн газар нь ЭМС-ын 2020 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн газрын үлгэрчилсэн дүрэм, бүтэц үйл ажиллагааны чиглэл”-ийн нэгдүгээр хавсралт, 2020 оны 37 дугаар тушаал “Тушаалд нэмэлт өөрчлөлт оруулах тухай”-ын дагуу 4 хэлтэс, 1 төвийн бүтэцтэй ажиллаж байна. Үүнд:

1. Удирдлага төлөвлөлт, санхүүгийн хэлтэс
2. Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтэс
3. Хяналт-шинжилгээ үнэлгээ, мэдээллийн хэлтэс
4. Эрүүл мэндийн хяналтын хэлтэс
5. Нийгмийн эрүүл мэндийн төв

Эрүүл мэндийн газар нь 2021-2024 онд хэрэгжүүлэх хөгжлийн стратеги төлөвлөгөө боловсруулан батлуулж 2021-2022 оны хэрэгжилтийг гарган ажилласан ба Эрүүл мэндийн сайдын 2022 оны 12 сарын 15 өдрийн А/609 дугаар тушаал “Эрүүл мэндийн салбарын 2022-2025 оны стратеги төлөвлөгөө батлах тухай” гарсантай холбогдуулан Дархан-Уул аймгийн Эрүүл мэндийн газрын стратеги төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах шаардлагатай болсон.

### **1.2.Үндэслэл**

“Монгол улсын урт хугацааны бодлогын баримт бичиг “Алсын хараа 2050”, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2017 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Эрүүл Дарханчууд” дэд хөтөлбөр, Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг тус тус үндэслэж боловсруулсан. Стратеги төлөвлөгөөг боловсруулахдаа Засгийн Газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам болон төлөвлөгөө боловсруулах аргачлалын дагуу боловсруулсан.

### **1.3.Хууль тогтоомжийн орчин**

- Монгол улсын Эрүүл мэндийн тухай хууль
- Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
- Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль

- Эрүүл ахуйн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Гамшгаас хамгаалах тухай хууль

### ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ


Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан "Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал"-ын дагуу салбарын чиг үүргийн мандатыг 2023 онд хийсэн.

Дүн шинжилгээ хийхдээ эрүүл мэндийн салбарын чиг үүргийг дараахь байдлаар тодорхойлсон байна.

#### Эрүүл мэндийн статистик үзүүлэлтүүд

##### 1.1. Хүн ам зүйн өөрчлөлт

- Хүн амын өсөлтийн 5 жилийн үзүүлэлт



Дархан-Уул аймгийн нийт хүн ам 2018 оноос 2022 онд 825-аар өссөн байна.

- Нас, хүйсийн бүтэц

Насны бүлэг	2018	2019	2020	2021	2022
0-4	12,350	11,850	11,925	11,467	11,629
5-9	11,280	11,402	11,393	11,704	11,973
10-14	7,940	8,748	8,728	9,370	10,008
15-19	7,191	6,555	6,546	6,551	6,690
20-24	7,788	7,151	7,122	6,992	6,869
25-29	9,269	8,337	8,331	7,867	7,467

Насны бүлэг	2018	2019	2020	2021	2022
30-34	8,654	8,562	8,529	8.784	8.852
35-39	7,575	7,351	7,316	7.461	7.595
40-44	7,174	6,980	6,959	6.940	7.061
45-49	6,438	6,328	6,314	6.478	6.644
50-54	5,874	5,793	5,764	5.782	5.758
55-59	4,922	4,969	4,975	5.070	5.314
60-64	3,102	3,386	3,372	3.675	3.770
65-69	1,884	1,962	1,954	2.028	2.281
70+	2,797	2,797	1,215	3.037	3.058

Насны бүтцийг харахад 2018 онтой харьцуулахад 0-14 насны хүүхдүүд 125-1956-аар өссөн байна. Харин хөдөлмөрийн насны 20-29 насны залуусын тоо 1007-1296-аар буурч, 30-49 насанд 35-111-ээр нэмэгдсэн, 50-аас дээш ахмад насныхан харьцангуй тогтвортой ба 248-1029-аар өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь идэр насны залуучуудын шилжилт хөдөлгөөнтэй холбоотой байж болох ба ахмад настнуудын тоо сүүлийн жилүүдэд нэмэгдэж байгааг харуулж байна.

➤ **Хүн ам хүйсийн бүтцээр**

Хүйс	2018	2019	2020	2021	2022
Нийт дүн	103,726	102,014	102,014	103.580	104.969
Эрэгтэй	50,918	50,125	50,125	50.890	51.549
Эмэгтэй	52,808	51,889	51,889	52.690	53.420

Хүйсийн харьцаа харьцангуй ойролцоо байна.

➤ **Дундаж наслалт**

он	нийт	эрэгтэй	эмэгтэй
2018	68.74	64.37	74.59
2019	68.84	64.43	74.73
2020	68.84	64.43	74.73
2021	68.63	64.31	74.43
2022	68.76	64.50	74.45

Хүн амын нийт дундаж наслалт 2018 оноос 2022 онд 0.02-аар нэмэгдсэн бол эрэгтэй дундаж наслалт 0.13-оор өссөн, эмэгтэй дундаж наслалт 0.14-аар буурсан үзүүлэлттэй байна.

➤ **Төрөлтийн тоо**

он	2018	2019	2020	2021	2022
Төрөлтийн тоо	2,528	2,525	2,238	2,170	1,985
Төрөлтийн коэффициент	24.8	24.7	23.2	1,786	1.641

Төрөлтийн тоо ойролцоо түвшинтэй ба дунджаар төрөлт 2470 байна.Огцом өсөлт ажиглагдсангүй.

➤ **Төрөлтийн тоо насны бүлгээр**

Насны бүлэг	2018	2019	2020	2021	2022
15-19	141	104	83	81	68
20-24	630	591	522	476	444
25-29	756	733	600	565	541
30-34	590	597	596	567	530
35-39	333	402	345	380	308
40-44	67	75	89	9	94
45-49	1	3	3	2	

Төрөлтийн насны бүлгээс харахад 25-29 нас хамгийн өндөр ба дундаж төрөлт 600, 20-24 насны дундаж төрөлт 522, 30-34 насны дундаж төрөлт 596 ба эдгээр нь гэр бүл төлөвлөлтийн тохиромтой нас юм. Харин эрт буюу 15-19 насны охидын төрөлтийн дундаж 115 ба 35-39 насны дундаж төрөлт 344.6, оройтсон буюу 40-44 насны төрөлтийн дундаж 87.6, 45-49 насны төрөлт 4.4 байна.

➤ **Нас баралтын тоо**

Аймаг	2018	2019	2020	2021	2022
Дархан-Уул	572	524	424	537	517

Хүн амын нас баралт 2018 оноос 55 тохиолдлоор буурсан ба жилд дунджаар 515 нас баралт гарч байна.

➤ **Нас баралт хүйсээр**

Хүйс	2018	2019	2020	2021	2022
Эрэгтэй	345	305	241	276	312
Эмэгтэй	218	219	183	261	205

Хүйсээр үзэхэд дунджаар эрэгтэйчүүдийн нас баралт 296 ба жилээс жилд 36 тохиолдлоор өссөн байна. Харин эмэгтэйчүүдийн нас баралтын дундаж 218 ба

эрэгтэйчүүдийн дунджаас 78 тохиолдлоор бага байна. Жилд дунджаар 13 тохиолдлоор буурч байна.

➤ **Хүн амын өвчлөлийн тэргүүлэх шалтгаан 10000 хүн амд**

№	Тэргүүлэх өвчлөл	2018	2019	2020	2021	2022
1	Амьсгалын тогтолцооны өвчин	1764.15	2717.55	893.5	1065.7	2500.3
2	Хоол боловсруулах тогтолцооны өвчин	1497.80	1305.49	794.4	1420.5	1521.0
3	Шээс бэлэгсийн тогтолцооны өвчин	681.75	712.91	178.9	784.9	657.9
4	Зүрх судасны тогтолцооны өвчин	1580.28	1247.02	311.0	911.1	1101.6
5	Гэмтэл хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг	321.81	298.08	149.1	259.0	235.1

Амьсгалын эрхтэн тогтолцооны өвчин өсөх хандлагатай ба 2018 онтой харьцуулахад 736.1 промилоор урьд оноос 1434.6 промилоор өссөн байна. Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчин 23.2-726.6 промилоор өссөн байна. Шээс бэлэгсийн тогтолцооны өвчин 2018 онтой харьцуулахад 23.85 промилоор буурсан боловч урьд оноос 127 промилоор буурч. Зүрх судасны тогтолцооны өвчин 2018 оноос 478,68 промилоор буурсан урьд оноос 190.5 промилоор өссөн үзүүлэлттэй байна. Харин гэмтэл хордлого, гадны шалтгаант эмгэг 2018 онтой харьцуулахад 86.71 промилоор буурсан урьд оноос 23.9 промилоор өссөн үзүүлэлттэй байна.

**Хавдрын өвчлөл, нас баралт 10000 хүн амд**

Хавдрын өвчлөл	2018		2019		2020		2021		2022 он	
	өвч	н/б	өвч	н/б	өвч	н/б	өвч	н/б	өвч	н/б
Элэг	7.9	6.7	9.1	7.8	8.2	6.9	6.7	6.4	8.1	6.6
Ходоод	3.3	3.2	3.3	2.8	2.2	1.8	3.8	2.9	4.1	2.8
Улаан хоолой	1.7	1.5	1.0	2.1	1.1	0.8	1.7	1.1	1.0	0.8
Уушиг	3.2	2.2	2.1	2.1	1.5	2.0	1.2	1.6	1.9	1.6

**Хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаан**

№	Тэргүүлэх өвчлөл	2018	2019	2020	2021	2022
1	Зүрх судасны тогтолцооны өвчин	25.58	19.98	14.44	19.9	20.0
2	Хавдар	15.14	17.65	12.89	13.3	15.3
3	Гэмтэл хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг	7.47	6.01	4.75	2.4	4.2
4	Хоол боловсруулах тогтолцооны өвчин	2.91	1.94	2.81	3.3	3.1
5	Амьсгалын тогтолцооны өвчин	1.07	0.39	0.58	2.7	2.9

**Эх, хүүхдийн эндэгдлийн үзүүлэлт**

№	Үзүүлэлт	2018	2019	2020	2021	2022
1	Эхийн эндэгдэл 100000 амьд төрөлтөд	83.1	0.0	0.0	136.7	0.0
2	Нялхсын эндэгдэл 1000 амьд төрөлтөд	10.8	7.5	9.3	6.8	10.4
3	Перинаталь эндэгдэл 1000 нийт төрөлтөд	9.9	10.0	6.7	3.2	4.5
4	5 хүртэл насны хүүхдийн эндэгдэл 1000 амьд төрөлтөд	13.7	9.6	12.5	10.9	13.6

2018-2019 онуудад эхийн эндэгдэлгүй ажилласан ба 2021 онд 3 эхийн эндэгдэл гарсан нь Ковидтой холбоотой ба 2022 онд эхийн эндэгдэлгүй ажилласан байна.

**ГУРАВ. АЛСЫН ХАРАА**

*Чадварлаг эмч мэргэжилтэнтэй, чанартай тусламж үйлчилгээ үзүүлэх*

**ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО**

*Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэнийг төлөвшүүлэхэд төр, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг өрнүүлэн 2025 онд дундаж наслалтыг 70-д хүргэнэ.*



ТАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Давуу тал	Сул тал
<p>Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт эрүүл мэндийн салбарын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх үйл ажиллагаа тусгагдсан.</p> <p>Эмнэлгийн тусламж үйлчилгээний хууль батлагдсанаар эмнэлгийн засаглал зах зээлийн жамаар хөгжих боломж бүрдсэн.</p> <p>Эрүүл мэндийн газрын удирдлагын зөвлөлөөр бодлогын асуудлыг шийдвэрлэдэг.</p> <p>Эрүүл мэндийн газар нь удирдлагын бүтэц тогтолцоотой.</p> <p>Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалт дэмжлэгийг жил бүр үзүүлдэг.</p> <p>Аймгийн Засаг даргын дэмжлэг, хөрөнгө оруулалт жилээс жилд нэмэгдэж байна.</p> <p>Шилэн дансны хууль хэрэгжиж, төсөв, санхүүгийн үйл ажиллагааны ил тод нээлттэй байдал сайжирсан.</p> <p>Эрүүл мэндийн ажиллагсдын цалин, төрөөс олгох тэтгэмжийн хэмжээ нэмэгдсэн.</p> <p>ISO чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлсэн.</p> <p>Олон улсын байгууллагуудын төсөл, хөтөлбөрийн хөрөнгө оруулалт хийгддэг.</p> <p>Тээврийн хэрэгслэл хангалттай</p> <p>Интернэт цахим сүлжээтэй , харуул хамгаалалт сайтай</p> <p>Хөдөлмөр хамгаалал, нормын хувцасаар тогтмол хангадаг.</p> <p>Хүний нөөцийн сонгон шалгаруулалтын, сэлгэн ажиллуулах, шагнал урамшууллын, шавьлан сургах журамтай.</p> <p>Ажлын тушаалын тодорхойлолтыг батлуулсан ба гүйцэтгэлийн гэрээ байгуулан хэрэгжилтийг ханган ажилладаг.</p> <p>Эмч, ажиллагсадын ажлын гүйцэтгэлийг үнэлэх журамтай, шалгуур үзүүлэлттэй ба үр дүнгийн урамшууллыг сар бүр олгодог.</p> <p>Эмч, ажиллагсдад унаа, хоолны мөнгө тогтмол олгодог.</p> <p>Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, Хууль эрх зүйг хариуцсан орон тооны мэргэжилтэнтэй.</p> <p>Эрүүл мэндийн газрын дэргэдэх ёс зүйн салбар зөвлөл ажилладаг.</p> <p>Хүний нөөцийг чадавхижуулах чиглэлээр мэргэжлийн нийгэмлэгүүдтэй хамтарч ажилладаг.</p>	<p>Эрүүл мэндийн салбарын удирдах мэргэшсэн ажилтны нөөцийн хомсдол үүсэх эрсдэлтэй.</p> <p>Эрүүл мэндийн газрын удирдах ажилтны чадвар, манлайлал харилцан адилгүй.</p> <p>Тусгайлсан эрүүл мэндийн удирдах ажилтныг мэргэшүүлэх сургалтын хөтөлбөргүй.</p> <p>Нийгмийн эрүүл мэнд урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсөв хангалтгүй.</p> <p>Эмч, мэргэжилтнүүдийн гадаад хэлний чадвар хангалтгүй тул гадаадад сургалтад хамруулахад бэрхшээлтэй.</p> <p>Эмч, ажиллагсадын ёс зүйн хандлагын төлөвшил жигд биш.</p> <p>Эмч, ажиллагсадын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд эрхзүйн орчин бүрдээгүй.</p> <p>Эрүүл мэндийн газрын барилга байгууламжийн насжилт их, хуучирсан</p> <p>Вирусын программ найдвартай биш, үнэ өндөртэй, төсөл хүрэлцдэггүй.</p> <p>Интернетын хурд хангалттай биш</p> <p>Эмч мэргэжилтнүүдийн компьютерийн чадавхи харилцан адилгүй</p> <p>Эмзэг бүлэгт чиглэсэн ЭМТҮ-ий хүртээмж, чанар хангалтгүй.</p> <p>Оношлогоо эмчилгээний зарим тоног төхөөрөмж дутагдалтай</p> <p>Эмч мэргэжилтний ёс зүй хандлагын байдал үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжид нөлөөлдөг</p> <p>Хэвлэл мэдээллийн байгууллагуудын үнэ өртөг өндөр</p>

<p>Эмийн тендер, төрөөс зарим эмийг үнэ төлбөргүй олгох ажлыг зохион байгуулах туршлагатай.</p> <p>Эрүүл мэндийн газар нь зориулалтын байртай, эмч ажилтнуудын ажлын өрөө тасалгааны зай талбай хүрэлцээтэй, тав тухтай</p> <p>Эрүүл мэндийн газар нь цахим сайтаар холбогдож, тушаал шийдвэр, зөвлөмжийг өгч цаг алдалгүй, мэдээлэл дамждаг.</p> <p>Харъяалах эрүүл мэндийн байгууллагуудад улирал бүр ХШҮ хийж, зөвлөмж арга зүйгээр хангаж байна.</p> <p>Төрийн байгууллагын ABLE программ ашигладаг.</p> <p>Шуурхай удирдлага, мэдээллийн төвтэй</p> <p>Эмч мэргэжилтнүүдийн мэргэжлийн чадавхижуулах сургалт тасралтгүй зохион байгуулдаг ба гардан сургалтын “Симуляци сургалтын төвтэй.</p> <p>НЭМТ-ийн тогтвортой бүтэц, зохион байгуулалттай</p> <p>Дархлаажуулалт, ХБИ-ны сувилахуй, Симуляци сургалтын, Чийрэгжүүлэлтийн, Хоолны сургалт, зөвлөгөө өгөх төвүүдтэй.</p> <p>Цахим дархлаажуулалтын программтай</p> <p>Орон нутгийн удирдлага, салбаруудын хамтын ажиллагаа, дэмжлэг сайн</p> <p>Урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээний баг тогтмол ажилладаг.</p> <p>“Явуулын дижитал Рентген” аппараттай</p> <p>Хүний нөөцийн санг бүрдүүлэх мэдээллийн нэгдсэн цахим программтай</p>	<p>Урьдчилэн сэргийлэх үзлэгээр илэрсэн өвчлөлийн эрүүлжилт хангалтгүй</p> <p>Эрүүл зүйн лабораторгүй тул нотолгоонд суурилсан тусламж үзүүлэхэд бэрхшээлтэй</p> <p>Хүн амын эрүүл мэндийн боловсрол эрүүл зөв зан үйлийн төлөвшил хангалтгүй</p>
<p align="center"><b>Боломж</b></p>	<p align="center"><b>Аюул</b></p>
<p>Эрүүл мэндийн газрын удирдах ажилтнуудыг системтэй удирдах ажилтны сургалтыг зохион байгуулж, чадавхижуулах</p> <p>Удирдах ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлд тулгуурласан урамшуулал, хариуцлагын тогтолцоог тодорхой болгох</p> <p>Аймгийн засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан асуудлуудыг санхүүжүүлэх асуудлыг Иргэдийн хуралд тавьж шийдвэрлүүлэх</p> <p>Төсөв санхүүгийн удирдлагаар бүх шатны менежерүүдийг сургаж, чадавхижуулах</p> <p>Эмч, ажиллагсадын ажлын гүйцэтгэл, үр дүн хариуцлагад суурилсан үр дүнгийн урамшууллыг олгох</p> <p>Эмч, ажиллагсадын ёс зүй хандлагыг сайжруулах хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх</p> <p>Хамгаалах хэрэгслэл, ариутгалын нөөц хангамж сайтай байвал эрсдэлд өртөх нь бага</p> <p>Сурч боловсрох нөхцөл боломж хангалттай</p>	<ul style="list-style-type: none"> <li>▪ Төсөв санхүүгийн хомсдол байгууллагын хөгжилд сөргөөр нөлөөлөх</li> <li>▪ Чадварлаг хүний нөөцийн хомсдолд орох</li> <li>▪ Ёс зүй хандлага нь үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг бууруулах</li> <li>▪ Хүний нөөцийн тогтвор суурьшил хангалтгүй байх</li> <li>▪ Эмнэлгийн тоног төхөөрөмжийн нөөцийг бүрдүүлэлт</li> <li>▪ Эмнэлгийн барилга байгууламжийн эрсдлийн үнэлгээг мэргэжлийн байгуулагуудаар хийлгэх</li> <li>▪ Цахимжсан сангийн нууц алдагдах</li> </ul>

<p>Зарим тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулах төсвийг нэмэх</p> <p>Шаардлагатай цахим программуудаар бүрэн хангах</p> <p>Шилэн дансны мэдээллийг тогтмолжуулах үйл ажиллагааг жигд болгох</p> <p>Эмч, мэргэжилтнүүдийн компьютерийн чадавхийг сайжруулах</p> <p>Цахим сангуудыг бүрдүүлэх</p> <p>Тусламж үйлчилгээний чанарын менежентийг сайжруулах</p> <p>Эмнэлгийн тусламжийн хуулийг хэрэгжүүлж зах зээлийн жамаар эмнэлгийн тусламжийг хөгжүүлэх боломжтой.</p> <p>Хүний нөөцийн үүрэг хариуцлага, мэргэжлийн ур чадварыг сайжруулах боломжтой</p> <p>Орон нутагтаа Анагаахын сургуультай тул эрдэм шинжилгээ судалгааны ажлыг хийх боломжтой</p> <p>Хэвлэл мэдээллийн байгууллагуудыг нийгмийн хариуцлагын хүрээнд эрүүл мэндийн сургалт мэдээллийг нэвтрүүлэх үнийн хөнгөлөлт үзүүлэх асуудлыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар дэмжүүлэх асуудлыг шийдвэрлүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> <li>▪ Сүлжээ серверт алдаа гарах, эвдрэх</li> <li>▪ Цахим халдлагад өртөх</li> <li>▪ Оношлогоо эмчилгээний алдаа эрсдэл гарах</li> <li>▪ Үйлчлүүлэгч иргэдийн эмнэлэгт хандах мэдлэг хандлага хангалтгүй</li> <li>▪ Хөдөлгөөнт хүн ам ихтэй</li> <li>▪ Иргэдийн эрүүл мэндийн боловсрол хангалтгүй нь эрүүл мэндийн зөв зан үйл төлөвшихөд сөргөөр нөлөөлөх.</li> <li>▪ Хувь хүний эрүүл мэндийн үүрэг хариуцлага, эрүүл мэндийн боловсрол хангалтгүй байгаа нь халдварт ба халдварт бус өвчлөлийн тархалтын байдалд нөлөөлж байна.</li> <li>▪ Үйлчлүүлэгчийн орох гарах хөдөлгөөн их байгаа нь халдвар хамгааллын дэглэм алдагдвал эрсдэлд өртөх</li> </ul>
---	---

## **ЗУРГАА. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО**

Орчин үеийн оншилгоо, эмчилгээний шинэ технологи нэвтрүүлж, эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй эмнэлгийн тусламж үйлчилгээг иргэдэд хүргэнэ.

### **ДОЛОО. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО БА САЛБАР, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН БҮТЦИЙН УЯЛДАА ЗУРАГЛАЛ**

2022 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд Нэгдсэн эмнэлэг 1, Өрхийн эрүүл мэндийн төв 5, Сумын эрүүл мэндийн төв 3, хувийн хэвшлийн ортой эмнэлэг 12, клиник эмнэлэг 53, сувилал 6, лаборатори 6, халдваргүйтгэл, шавьж мэрэгч устгал 3, эм хангамжийн байгууллага 7, эмийн сан 67 ажиллаж эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж байна.

## Эрүүл мэндийн байгууллагын зураглал



### НАЙМ. СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫГ ХЭМЖИХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, СУУРЬ БОЛОН ЗОРИЛТОТ ТҮВШИН

#### АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ /2023-2026/

И/Д	Үзүүлэлт	Суурь үзүүлэлт 2022	Хүрэх түвшин			
			2023	2024	2025	2026
1	Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгэнд хамрагдсан 18 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь	85.7	90.7	92.0	94.0	96.0
2	Чихрийн шижин хэв шинж-2 өвчний эрт илрүүлгэнд хамрагдсан 40 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь	79.6	84.6	89.6	94.6	96.6
3	Хөхний өмөнгийн эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан 20 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн тоо	28960	30408	30908	31408	31608
4	Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлгэнд хамрагдсан 30 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь	58.6	63.6	68.6	73.5	78.5
5	Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь	27.6	32.6	37.5	42.5	47.5
6	В вируст гепатитийн эсрэг сэргийлэх тарилгын 24 цагийн хамралтын хувь	100	Суурь үзүүлэлт ээс доошгүй	99.0	99.0	99.0
7	Тавт (сахуу, хөхүүл ханиад, татран, В гепатит, хемофилюсинфлюенза) сэргийлэх тарилгын хамралтын хувь /3-р тун/	99.9	Суурь үзүүлэлт ээс доошгүй	99.0	99.0	99.0
8	Улаанбурхан-гахайн хавдар-улаануудын (УГУ) эсрэг сэргийлэх тарилгын хамралтын хувь /2-р тун/	99.8	Суурь үзүүлэлт ээс доошгүй	99.0	99.0	99.0
9	Эхийн эндэгдлийн түвшин (100 000 амьд төрөлт тутамд)	0.0	0.0	0.0	0.0	0.0

10	Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд)	10.5	10.0	7.8	7.2	7.0 /8/
11	Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд)	7.5	7.0	6.8	6.5	6.2
12	5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд)	13.5	12.8	11.0	10.0	9
13	Амьгүй төрөлтийн түвшин (1000 төрөлт тутамд)	4.5	4.0	3.8	3.6	3.4
14	Жирэмсний эхний 3 сард хяналтад орсон эхийн эзлэх хувь	94.8	97.8	98.0	98.5	98.7
15	Өсвөр насны 1000 эмэгтэйд ногдох төрөлтийн түвшин	8.5 27.6	7.5	7.2	7.0	6.8
16	Сүрьеэгийн өвчлөлийн түвшин, 10 000 хүн амд	10.0	9.5	9.3	9.1	8.8
17	Вирус хепатитын өвчлөлийн түвшин, 10 000 хүн амд /B вирусийн шинэ тохиолдол /	0.9	0.7	0.6	0.4	0.2
18	Зүрх судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтын түвшин, 10 000 хүн амд	19.8	19.6	17.6	16.0	15.0
19	Хорт хавдраас шалтгаалсан нас баралтын түвшин, 10 000 хүн амд	15.2	14.7	14.5	14.3	14.1
20	Амиа хорлож нас барсан тохиолдлын түвшин, 10 000 хүн амд	0.8	0.6	0.4	0.3	0.2

**Стратеги боловсруулсан ажлын хэсэг:**

М.Мөнхбаатар -Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хэлтсийн дарга

Б.Сарнайцэцэг -НЭМТ-ийн дарга

Ч.Мөнхцэцэг -Хяналт-шинжилгээ үнэлгээ,дотоод аудит хариуцсан мэргэжилтэн

Б.Төгсөө - Хүний нөөцийн мэргэжилтэн

Б.Мөнхзул -Статистикийн мэргэжилтэн

## НАЙМ. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот хугацаа /оноор/ түвшин			Санхүүжилт
				2023	2024	2025	
<b>ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРЭГ: ХҮН АМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ, ХАМГААЛАХ</b>							
<b>ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ 1. НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ</b>							
Зорилт 1. Хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж8 НЭМТҮ-г бэхжүүлэх замаар иргэдийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг оношилгоо шинжилгээнд жил бүр 30-аас доошгүй хувийг хамруулна.	"Эрүүл идэвхитэй амьдрал" нотолгоонд суурилсан үнэн зөв мэдээлэл бүхий веб хуудас нээн ажиллуулах	Веб хуудсаар бэлтгэн түгээсэн сэдэвчилсэн мэдээллийн тоо	10	15	20	25	УТ, ОНТ ОУ төсөл хөтөлбөр
	Эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах үйл ажилагааг зохион байгуулах	Эрүүл мэндийг дэмжих төвд үзлэгт хамрагдсан иргэдийн тоо, хувь	27	50	65	80	ЭМДС
	"Эрүүл, идэвхтэй амьдрал арга хэмжээний төлөвлөгөө" хэрэгжүүлэх	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	88	90	92	94	УТ ЭМДС, төсөл хөтөлбөр
	"Хавдрын эсрэг арга хэмжээний төлөвлөгөө" хэрэгжүүлэх	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	80	83	86	90	УТ, ЭМДС, ОУ төсөл хөтөлбөр
	"Харшлаассэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө" хэрэгжүүлэх	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	82	85	88	90	УТ, ЭМДС, ОУ төсөл хөтөлбөр
	"Эрүүл чийрэг эр хүн арга хэмжээний төлөвлөгөө" хэрэгжүүлэх	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	70	75	80	85	УТ, ЭМДС, ОУ төсөл хөтөлбөр
	"Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд арга хэмжээний төлөвлөгөө" хэрэгжүүлэх	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	84	86	88	90	УТ, ЭМДС, ОУ төсөл хөтөлбөр
	"Орчны эрүүл мэнд арга хэмжээний төлөвлөгөө" хэрэгжүүлэх	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	78	80	82	85	УТ, ЭМДС, ОУ төсөл хөтөлбөр

	Элэг бүтэн Монгол арга хэмжээний төлөвлөгөө хэрэгжүүлэх	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	50	70	85	УТ, ЭМДС, ОУ төсөл хөтөлбөр
	Товлолт дархлаажуулалтын хамрагдалтыг нэмэгдүүлнэ	Товлолт дархлаажуулалтын хамрагдалтын хувь	98	98.5	99	99.5	Улсын төсөв
Зорилт 2. Гэнэтийн аюул, байгалийн гамшиг, шинэ болон сэргэн тархаж байгаа халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тандан судлах, хариу арга хэмжээ шуурхай авах чадавхийг бүрдүүлнэ.	Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үеийн хариу арга хэмжээ авах эмч мэргэжилтнүүдийн чадавхийг сайжруулах дадлага сургалтыг зохион байгуулна.	Сургалтад хамрагдсан хүний тоо	164	200	250	300	УТ, ОНТ ОУ төсөл хөтөлбөр
	Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хариу арга хэмжээний нөөцийн бэлэн байдлыг хангах	Нөөцийн бэлэн байдлын судалгаа	1-2 сарын нөөцтэй	1-2 сарын нөөцтэй	1-2 сарын нөөцтэй	1-2 сарын нөөцтэй	УТ, ОНТ ОУ төсөл хөтөлбөр
	Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх төлөвлөгөөг хэрэгжүүлэх	-	70	75	80	85	УТ, ОНТ ОУ төсөл хөтөлбөр
	БЗДХ-ыг бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх	Идэвхитэй илрүүлэг үзлэгт хамрагдалтын тоо -Эмчилгээнд хамрагдсан хувь	5000	6000	7000	8000	УТ, ОНТ ОУ төсөл хөтөлбөр
	Сүрьеэ өвчний тархалт, нас баралтыг бууруулах, сүрьеэгээс сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах	Илрүүлэг үзлэг, сургалт мэдээлэлд хамрагдсан хүний тоо	5056	5000	5500	6000	УТ, ОНТ ОУ төсөл хөтөлбөр
<b>ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ 2. ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ</b>							
Зорилт-4. Оношилгоо эмчилгээний орчин үеийн	Хүн амын нягтрал, эрэлт хэрэгцээтэй уялдуулан эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх анхан шатны эрүүл мэндийн байгууллага, нэгжийн тоог нэмэгдүүлнэ.	Өрхийн эрүүл мэндийн төвийг ергөтгөл	-	Аминх олбоо ӨЭМТ	Гэрэлтэй ӨЭМТ	-	УТ

анагаах ухааны дэвшилтэт технологийг нэвтрүүлэн иргэд орон нутагтаа эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах боломжийг нэмэгдүүлж лавлагаа шатлал руу илгээх иргэдийн урсгалыг 10 хувиар бууруулна.	Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд үзүүлэх эмнэлгийн анхан шатлалын тусламж, үйлчилгээнд шинэ дэвшилтэт арга технологийг нэвтрүүлэх, лабораторийн оношилгоо, өдрийн, сэргээн засах, гэрээр үзүүлэх тусламжийг бэхжүүлэх	Тусламж үйлчилгээ авсан иргэдийн хувь	26%	40%	55%	70%	УТ ОНТ
	Нэгдсэн эмнэлэгт зүрхний шигдээс, тархины цус харвалтын оношилгоо, эмчилгээний нэгжийг байгуулах	-Нэгж зохион байгуулж, тусламж үйлчилгээ авсан иргэдийн тоо	-	Тохиолдлын тоогоор	Тохиолдлын тоогоор	Тохиолдлын тоогоор	ОНТ
	Амбулаторийн тусламж үйлчилгээний үйл ажиллагааг нэмэгдүүлж төрөлжсөн нарийн мэргэжлийн эмчийн үзлэгийг кабинетүүд нээх	Нэмэгдүүлсэн кабинет	-	2	4	6	УТ
	Өдрийн эмчилгээний тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх	Өдрийн эмчилгээнд хамрагдсан иргэдийн тоо	500	600	700	800	УТ
	Нэгдсэн эмнэлгийн оношилгоо, эмчилгээний чадавхийг сайжруулах, дэвшилтэт технологийг нутагшуулахад дэмжиж ажиллана. (Өвдөгний үений хагалгааг нэмэгдүүлэх, урологи түрүү булчирхайн хагалгааг нутагшуулах, эмэгтэйчүүдийн дурангийн мэс засал, 48, 72, 96 цагийн холтер, бүлэн хайлуулах эмчилгээг нэвтрүүлэх)	тусламж үйлчилгээ авсан иргэдийн тоо	41	50	65	80	УТ, ОНТ ОУ төсөл хөтөлбөр
	Хавдрын хими эмчилгээг орон нутагтаа үзүүлэх	Тусламж үйлчилгээ авсан иргэдийн тоо	49	Тохиолдлын тоогоор	Тохиолдлын тоогоор	Тохиолдлын тоогоор	УТ ОНТ



Зорилт-5. Яаралтай тусламжийн чанар, хуртээмж, чадавхийг сайжруулж, парк шинэчлэл хийнэ.	Эмнэлгийн яаралтай болон түргэн тусламжийн парк шинэчлэл хийх	Парк шинэчлэл хийгдсэн тоо	3	2	4	5	УТ, ЭМДС, ОУ төсөл хөтөлбөр
	Эмнэлгийн яаралтай болон түргэн тусламжийн чиглэлээр эрүүл мэндийн ажилтан бэлтгэх	Яаралтай, түргэн тусламжийн үйлчилгээнд ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтны тоо	2	2	3	4	ОУ төсөл хөтөлбөр

**ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ: 3. ЭМ ЗҮЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ**

Зорилт-6. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар аюулгүй байдал, хангамж, хуртээмжийг нэмэгдүүлэн зайлшгүй шаардлагатай эмийн хуртээмжийг 85 хувьд хүргэнэ.	Эм, эмнэлгийн хэрэгслийн цахим бүртгэл, хяналтыг сайжруулах	цахим бүртгэл шивэлтийн хувь	90	92	94	96	ОНТ
	Эм зүйн салбарт мөрддөг стандартад үнэлгээ хийж, хэрэгжилтийг хангуулан ажиллах	Үнэлгээнд хамрагдсан байгуулагын тоо, өгсөн зөвлөмж	45	25 эмийн санд	45 эмийн санд	60 эмийн санд	УТ
	Антибиотикт тэсвэртэй нянгийн тэсвэржилтийг тандаж, үүсэхээс сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах	Зохион байгуулсан үйл ажиллагаа, хамрагдсан хүний тоо	210 эмнэлгийн ажилтан	200	250	300	-
	Эмч мэргэжилтэн, иргэдэд эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх сургалт мэдээллийг зохион байгуулах	-сургалтад хамрагдсан хүний тоо	1631	2000	2500	3000	-
	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар, тохируулга, баталгаажилтыг жил бүр хийж ажиллах	Баталгаажилт, тохируулга хийгдсэн тоног төхөөрөмжийн тоо	31	40	45	50	Улсын төсөв

**ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ: 4. ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖИЛ**

<p>Зорилт-7. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг чадавхижуулж, нийгмийн хамгааллыг сайжруулах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллана.</p>	Салбарын хүний нөөцийн 2022-2025оны сургалт хөгжлийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	60	75	90	Орон нутгийн төсөв
	Эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхижуулах, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор тасралтгүй сургалтад хамруулах үйл ажиллагааг зохион байгуулах	-Сургалтад хамрагдсан эмч, мэргэжилтний тоо	14 чиглэлээр 1175 эмнэлгийн ажилтан	500	800	1000	УТ ОНТ
	Эмнэлгийн мэргэжилтнийг мэргэжлийн чиглэлээр өндөр хөгжилтэй улс орнуудад богино болон урт хугацаагаар сургаж мэргэшүүлэхэд дэмжлэг үзүүлэх	-Гадаадад сургалтад хамрагдсан эмч, мэргэжилтний тоо	-	8	10	15	УТ ОНТ
	Хэвтэн эмчлүүлэгч бүхий орны ачаалал ихтэй тасгуудад хэрэгцээнд тулгуурлан туслах сувилагчийн тоог нэмэгдүүлэх	Нэмэгдсэн туслах сувилагчийн тоо	4	10	15	20	УТ
	Эрүүл мэндийн удирдах ажилтан, менежерүүдийн ур чадварыг нэмэгдүүлэх, чадавхижуулах сургалтад хамруулах	сургалтад хамрагдсан удирдах ажилтны тоо	80	100	120	150	УТ ОНТ
	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг тасралтгүй сайжруулах үйл ажиллагааг зохион байгуулах, мэргэжлийн нийгэмлэг, холбоодын хамтын ажиллагааг сайжруулах	- Ёс зүйг сайжруулах чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагаа -Сургалтад хамрагдсан мэргэжилтний тоо, хувь	250	300	350	400	УТ ОНТ

	Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг сайжруулах төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах	Хэрэгжилтийн хувь	90	92	94	96	УТ ОНТ
<b>ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ: 5. ЭРҮҮЛ МЭНДИЙН САНХҮҮЖИЛТ</b>							
Зорилт 8. Эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээг худалдан авч байхаар эрүүл мэндийн даатгалын үр дүн, үр ашиг бүхий санхүүжилтэд шилжүүлж бүх нийтийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулна.	Аймгийн нэгдсэн эмнэлгийг гүйцэтгэлийн санхүүжилт болон удирдлагын бие даасан хэлбэрт үе шаттай шилжүүлж, ажилтны гүйцэтгэлд суурилсан цалин, урамшууллын тогтолцоог төлөвшүүлэх	Гүйцэтгэлийн санхүүжилт	Гүйцэтгэлээр	Гүйцэтгэлээр	Гүйцэтгэлээр	Гүйцэтгэлээр	ЭМДС
	Төсөв санхүүгийн ил тод нээлттэй байдлыг хангах	Шилэн дансны мэдээллийн хувь	98.9	Шилэн дансны мэдээллийн хувь 99	Шилэн дансны мэдээллийн хувь 99.5	Шилэн дансны мэдээллийн хувь 100	-
<b>ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ: 6. ЭРҮҮЛ МЭНДИЙН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ</b>							
Зорилт 9 Телемедицин, цахим эрүүл мэндийн дэвшилтэт технологийг өргөжүүлнэ	Алсын зайн оношилгоо, зөвлөгөө, мэдээлэл солилцох (теле медицин) тусламж үйлчилгээг нэмэгдүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бүх шатлалд хэрэгжүүлж ажиллах	- тусламж үйлчилгээ авсан иргэдийн тоо	186	Тохиолдлын тоогоор	Тохиолдлын тоогоор	Тохиолдлын тоогоор	-
	Өрх, сумын эрүүл мэндийн төвд үзүүлэх эмнэлгийн анхан шатлалын тусламж, үйлчилгээнд Мобайл технологийн хамрагдалтыг нэмэгдүүлэх	Хамрагдсан хүний тоо	2767	1500	2000	2500	
Зорилт 10 Эмч, мэргэжилтэнд эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг	Эмч, мэргэжилтэнд эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх	Эрдэм шинжилгээ судалгааны	8	10	12	14	УТ ОНТ

хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлнэ.		ажил хийсэн байна					
<b>ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ: 7. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ</b>							
Зорилт-11. Эрүүл мэндийн салбарын удирдлага зохион байгуулалт, ил тод байдлыг дэмжиж ажиллана.	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд иргэн, төрийн бус байгууллагын Нийгмийн эгэх хариуцлагыг оролцоог нэмэгдүүлж ажиллана.	Хамтран ажилласан ТББ	8	10	12	14	ТББ
	Төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх	Хамтран ажилласан хувийн хэвшлийн байгууллагууд	20	25	30	35	ОНТ ОУ төсөл хөтөлбөр
	250 ортой шинэ эмнэлэг барих төсөл хэрэгжүүлнэ	Шинэ эмнэлгийн барилга баригдсан байна	-	Барилгын зураг төсөв гаргах	Улсын төсөвт суулгах	Барилгын ажил эхлэх	УТ ОУ төсөл хөтөлбөр ОНХӨ
	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний ил тод байдлыг хангаж ажиллах	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний ил тод байдлын хэрэгжилтийн хувь	78	85	90	95	-